

# Балар эртний түүх

2-р хичээл

Алдагдаж, дахин олдсон аз  
жаргал (Пентатекийн 3-р хичээл)

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2012 by Гуравдахь мянган жил үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Энэхүү материалыг 2007 онд Ийгли ТВ-н Христийн Нэвтрүүлгийн албанд орчуулсан бөгөөд Библийн зарим эшлэлүүдийг Монголын Библийн Нийгэмлэгийн Шинэ Гэрээ©1990 Эхлэл, номноос зохиогчийн зүгээс Ийгл ТВ-ын Христийн нэвтрүүлгийн албанд өгсөн зөвшөөрлийн дагуу оруулсан.

Библийн бусад эшлэлийг Ариун Бичээс Нийгэмлэгийн Ариун Библи ©2004-ээс авлаа.

### **ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ**

ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛ нь 1997 онд ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН, АШГИЙН БУС, ХРИСТИТГЭЛИЙН САЙНМЭДЭЭНИЙ ҮЙЛЧЛЭЛ БӨГӨӨД ДАРААХ ТАЛБАНУУДАД ЧИГЛЭДЭГ:

#### **БИБЛИЙН БОЛОВСРОЛЫГ. БҮХ ДЭЛХИЙД. ҮНЭГҮЙ.**

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид теологийн мэргэжлийн сургагч багш нар байдаг бөгөөд орчуулагчид нь орон нутгийнхаа унаган хэлтэй теологийн мэдлэгтэй хүмүүс байдгаараа давуу талтай. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл <https://www.thirdmill.org> цахим хуудсаар зочлоорой.

# Гарчиг

<b>Удиртгал .....</b>	<b>1</b>
<b>Утга зохиолын бүтэц .....</b>	<b>1</b>
Тойм .....	1
Цэцэрлэгт .....	2
Хүний амьдралын нөхцөл сайжирсан нь .....	2
Хүний амьдралын нөхцөлийг хараасан нь .....	2
Хүн Цэцэрлэгээс хөөгдсөн нь .....	2
Тэгш хэм .....	3
Эхлэл ба төгсгөл .....	3
Дундах хэсгүүд .....	4
<b>Эх утга .....</b>	<b>5</b>
Цэцэрлэг .....	5
Онцлог .....	5
Ариун байдал .....	7
Үнэнч байдал .....	9
Ээдэнд .....	9
Хинаанд .....	10
Үр дагавар .....	11
Үхэл .....	11
Өвчин зовлон .....	12
Цэцэрлэгээс хөөгдсөн нь .....	13
<b>Орчин үеийн хэрэгжүүлэлт .....</b>	<b>15</b>
Эхлэл .....	15
Пууль .....	16
Матай .....	17
Үргэлжлэл .....	18
Пууль .....	18
Яахооб .....	18
Төгсгөл .....	19
Ром .....	19
Үзэгдэл .....	20
<b>ДҮГНЭЛТ .....</b>	<b>21</b>
<b>ҮГСИЙН ТАЙЛБАР .....</b>	<b>22</b>

# Балар эртний түүх

## 2-р хичээл

### Алдагдаж, дахин олдсон аз жаргал

#### УДИРТГАЛ

---

Хүн болгон хэзээ нэгэн цагт ямар нэг юмаа алдаж үзсэн байх. Магадгүй ном ч юм уу. Эсвэл гэрийн чинь түлхүүр ч байж магад. Та яадгийг мэдэхгүй ч, би иймэрхүү зүйлээ алдвал хамгийн түрүүнд явсан замаараа эргэн явдаг. Ядаж л бодол санаандаа алхам алхмаар буцан явж, нөгөө зүйлээ хаана тавьснаа санахыг хичээдэг. Үүнийхээ дараагаар буруу хийснээ засдаг. Түлхүүрээ байх ёстой газарт нь буюу ширээн дээр тавьж, номоо тавиур дээр нь тавьдаг. Ингэж явсан замаараа буцан явах буюу алдаагаа залруулах нь хаясан зүйлээ олох хамгийн шилдэг арга гэж би боддог.

Мөшэх Израйльчуудыг Адаам, Хаваах хоёрын явсан замыг санаж, хийсэн алхмыг нь харахыг уриалахын тулд тэд аз жаргалаа хэрхэн алдсан тухай бичжээ. Зөвхөн энэ түүхийг судалж байж л Израйльчууд мөнхийн аз жаргалыг дахин олж авах найдварыг олох байв. Мөшэхийн Израйльд өгсөн энэ урам зориг нь өнөөдөр Ертөнцийн Эзэний бидэнд хандан хэлж буй үг гэдгийг бид харах болно. Адаам, Хаваах хоёрын замаар эргэн явснаар өнөөгийн Есүст итгэгчид ч мөн мөнхийн жаргалтай газрыг олох болно.

Эхлэл 2 ба 3-р бүлгийг бид 3 хэсэгт хувааж судална. Эхлээд Библийн энэ хэсгийг утга зохиолын бүтцийг нь судлах болно. Харин дараа нь эдгээр бүлгийн эх утгыг судалж, Мөшэх яагаад үүнийг Израйлийн үр удамд зориулж бичсэн болохыг ойлгоно. Гуравдугаарт, энэхүү хэсгүүдийг амьдралдаа хэрхэн хэрэглэх тухай Шинэ Гэрээнд ямар удирдамж байдагт бид анхаарлаа хандуулах болно. Одоо Эхлэлийн 2,3-р бүлгийн утга зохиолын бүтцийг авч үзье.

#### УТГА ЗОХИОЛЫН БҮТЭЦ

---

Эхлэл 2, 3-р бүлэг маш урт бөгөөд олон сэдвийг хөнддөг ч гэсэн нэгдмэл нэгэн хүүрнэлийг бий болгодог юм. Энэ хэсгийг сайн ойлгохын тулд хоёр бүлгийг утга зохиолын хувьд нэг нэгж болгон харах хэрэгтэй. Эхлэл номын 2,3-р бүлгийн утга зохиолын бүтцийг судлахдаа бид хоёр асуудлыг голчлон авч үзнэ. Эхлээд бид эдгээр бүлгүүдэд гарах гол хэсгүүдийн тоймыг хараад, дараа нь эдгээр өөр өөр хэсгүүдийн гол чухал тэгж хэмийг тайлбарлах замаар Мөшэх Израйльчуудад хандан хэлсэн үндсэн санааг барьж авах болно. Одоо Эхлэл 2,3 бүлгийн утга зохиолын бүтцийг ерөнхийд нь харцгаая.

#### Тойм

2-р бүлгийн 4-р ишлэлийн эхэн хагаст гардаг товч гарчгаас гадна, энэ хоёр бүлгийг сэдэв болон дүрийн өөрчлөлтөөс нь хамааран дөрвөн үндсэн хэсэгт хувааж болно. Бид эдгээр дөрвөн хэсгээр аялан, гол агуулгыг багцлан харах хэрэгтэй.

## Цэцэрлэгт

Бидний хийх анхны гайхалтай алхам бол Эхлэл 2:4-17 юм. Энд Ертөнцийн Эзэн Адаамыг Ээдэн цэцэрлэгт аваачдаг. Библийн энэ хэсэг Ээдэн цэцэрлэгийн дэлгэрэнгүй дүрслэлээр эхэлдэг бөгөөд эндээс харвал уг цэцэрлэг нь бүхэлдээ ажиллаж, амьдрахад үнэхээр тохиромжтой сайхан газар байжээ. Энэ хэсэг Ертөнцийн Эзэн Адаамыг бүтээж, түүнд цэцэрлэг дотор ажиллах тушаал өгч байгаагаар үргэлжлэнэ. Ертөнцийн Эзэний хайр энэрлээр Адаам Түүний өмнөөс Ээдэн цэцэрлэгийг харж хамгаалах эрхэм үүргийг хүлээдэг.

## Хүний амьдралын нөхцөл сайжирсан нь

Хүүрнэлийн маань дараагийн хэсэг бол 2-р бүлгийн 18-25-р ишлэл юм. Үүнийг бид “Хүний амьдралын нөхцөл сайжирсан нь” хэмээн нэрлэж байна. Энэ хэсэгт Ертөнцийн Эзэн Адаамд бүр ч агуу ивээлүүдийг өгдөг. Уг хэсэг 2:18-д гарах нэгэн шинэ асуудлыг танилцуулснаар эхэлж байна. Ертөнцийн Эзэн Адаамыг хараад:

Ганцаараа байх нь хүнд таатай биш юм. Түүнд таарч тохирсон нэг хань бүтээж өгье (Эхлэл 2:18).

2:18-25-ын үлдсэн хэсэгт Ертөнцийн Эзэн дээрх асуудлыг хэрхэн шийдсэн тухай гардаг. Адаам араатан амьтдын дундаас хамтрагч болохоор нэгнийг эрдэг боловч эцэст нь Ертөнцийн Эзэн эмэгтэй хүнийг бүтээж, Адаам дээр авчирдаг. Ийнхүү Ертөнцийн Эзэн Адаам, Хаваах хоёрт аль хэдийн гайхалтай байсан амьдралыг улам сайжруулсан юм.

## Хүний амьдралын нөхцөлийг хараасан нь

Хүүрнэлийн маань гуравдугаар хэсэг нь 3:1-21 бөгөөд үүнийг бид “Хүний амьдралын нөхцөл хараагдсан нь” хэмээн нэрлэж байна. 3-н 1 дээр уруу татагч могой хэмээх шинэ сэдэв, шинэ дүр гарч ирдэг. Үүнээс хойш 3:1-21-т могой хүнийг хэрхэн уруу татаж, үүнээс ямар үр дагавар гарсныг харуулдаг. Хаваах могойд уруу татагдан Адаамын хамтаар хориотой жимснээс идэж, аймшигтай хараалд унана.

## Хүн Цэцэрлэгээс хөөгдсөн нь

Олон сэдвийг хамарсан Библийн энэ хэсгийн дөрөв дэх нь 3:22-24 буюу бидний нэрлэснээр “Хүн Цэцэрлэгээс гарсан нь”. Энэ хэсэгт өөр нэгэн сэдэв гардаг нь Ертөнцийн Эзэн амьдрал өгөгч модны тухай ярьдаг хэсэг юм. 3:22 ишлэл дээр,

Хүн... “амьдрал өгөх” модноос жимс авч идээд мөнх амьдарч

болохгүй (Эхлэл 3:22).

Адаамыг энэ модноос идүүлэхгүйн тулд Ертөнцийн Эзэн түүнийг Ээдэн цэцэрлэгээс хөөж, дахин тийш оруулахгүйн тулд үүдэнд нь эргэлдэн хөдөлж байдаг галт сэлэм барьсан ер бусын харуулыг тавьсан юм. Энэ цагаас эхлэн хүн Ээдэн цэцэрлэгт орох эрхгүй болж, Ертөнцийн Эзэнтэй шууд харилцах боломжгүй болсон билээ.

## Тэгш хэм

Энэ хүүрнэлийн тэгш хэмийг олж харахын тулд түүхийн эхлэл ба төгсгөлийн хооронд орших тэнцвэртэй байдал, дараа нь голын хоёр хэсэг дэх тэгш хэмийг хамтдаа харах болно. Эхлээд түүхийнхээ эхлэл, төгсгөл хоёрыг харцгаая.

### Эхлэл ба төгсгөл

Эхлэл 2:4-17 болон 3:22-24-т гарч буй хэсгүүд дор хаяж гурван чухал талаараа хоорондоо асар их ялгаатай байгааг харж болно. Эхний ялгаа нь байршил. Энэ нь 2:7 дээр Ертөнцийн Эзэн Адаамыг төгс аз жаргал бүхий цэцэрлэгт аваачиж байгаагаас эхэлдэг. Адаам ер бусын ивээлээр дүүрэн газарт ажиллаж, амьдарч байлаа. Хоол хүнс нь шим тэжээлтэй бөгөөд амьдрал тэтгэгч усаар ундаалж, гайхамшигт үнэт чулуу түүний эргэн тойронд байсан. Харин 3:24 ишлэл дээр Ертөнцийн Эзэн Адаам, Хаваах хоёрыг төгс аз жаргалтай цэцэрлэгээс хөөн гаргадаг. Эндээс хүн төрөлхтөн амьдрахад хамгийн тохиромжтой газар нь Ээдэн цэцэрлэг байсан гэдэг нь харагдаж байна.

Дараагийн ялгаа нь хоёрдугаар хэсэгт гарах онцгой модод-ын ялгаа юм. 2:4-17-т “амьдрал өгөгч мод” болон “сайн мууг таниулагч”-хоёр модны тухай гардаг бол, 2:16-р ишлэлд зөвхөн сайн мууг таниулах модонд анхаарлаа хандуулж байна. Энэ мод нь хүнд сайн сайхан болон гэм бурууг ялган мэдүүлэх хүч чадалтай байв. Энэ модны жимсийг идвэл хүний нүд нээгдэж урьд өмнө нь харж байгаагүй зүйлээ харах боломжтой болох байлаа.

Харин уг хүүрнэлийн төгсгөлд (3:22-24) Ертөнцийн Эзэн сайн мууг мэдүүлэгч модыг дурдалгүйгээр зөвхөн амьдрал өгөгч модны тухай ярьж байна. Энэ мод нь хүнд мөнхийн амьдрал өгөх чадалтай байсан. Харин Ертөнцийн Эзэн Адаамыг хөөж энэ модонд хүрэх эрхийг нь хассан. Ийнхүү нэгэн цагт хүн аз жаргалтай цэцэрлэгт байж, түүний ивээлүүдийг хүртэх боломжтой байсан бол Ертөнцийн Эзэний тушаалаар энэ бүхэн өөрчлөгдсөнийг харуулж байна.

Бидний үзэж буй түүхийн эхлэл төгсгөл хоёрын хоорондох гурав дахь ялгаа нь хүний үүрэг даалгавар. 2:15-д Ертөнцийн Эзэн Адаамд ямар нэг хүндрэл, бэрхшээлгүй “ерөөгдсөн ажлыг” даалгаж өгсөн байна. Харин 3:23-т Ертөнцийн Эзэн Адаам, Хаваах хоёрыг цэцэрлэгээс хөөж, цэцэрлэгийн гаднах хүнд хэцүү ажлыг даалган, шийтгэсэн. Энэ эсрэгцэл нь мөн уг түүхэнд чухал үүргийг гүйцэтгэж байна. Хүн төрөлхтөн Ээдэн цэцэрлэг дэх гайхамшигт амьдралаа алдаад зогсоогүй, цэцэрлэгийн гаднах хүнд хэцүү ажил бидэнд оногдсон юм.

Эхлэл номын 2-3-р бүлгийн эхлэл ба төгсгөлийн хоорондох ялгаа нь бидний

анхаарлыг энэ хүүрнэлийн хамгийн чухал тал руу хандуулж байна. Мөшэх балар эртний үед хүн төрөлхтний нөхцөл байдалд гарсан асар том өөрчлөлтийн тухай бичсэн байна. Ертөнцийн Эзэн анх хүнийг Өөрийн цэцэрлэгт амьдруулахаар бүтээсэн боловч, Адаам, Хаваах хоёрын хийсэн гэм тэднийг хүндрэл бэрхшээлд оруулж, мөнхийн амьдралыг өгдөг модноос тусгаарлажээ. Яг энэ өөрчлөлт Мөшэх Израйльчуудыг амласан газар луу дагуулж байхад тохиолдсон явдалтай шууд холбогдож байгааг бид харах болно. Израйльчууд Египетэд аймшигтайгаар боолчлогдож байсан нь Ээдэн цэцэрлэгээс холдсонтой адил байсан ба Ээдэнд байсан ивээл ерөөл тэдэнд хэрэгтэй байв.

## Дундах хэсгүүд

Захын хоёр хэсэг хоорондоо ямар ялгаатайг харсан бол одоо дундах хоёр хэсэгт анхаарлаа хандуулъя /2:18-25 болон 3:1-21/. Дундах энэ хоёр хэсэг нь эхлэл болон төгсгөлийг холбодог ба хоорондоо дор хаяж гурван тал дээр ялгаатай.

Эхний ялгаа нь Ертөнцийн Эзэн ба хүн хоёрын хоорондын харилцаан дээр гарч ирж байна. Түүхийн хоёрдугаар хэсэгт бид Адаам, Ертөнцийн Эзэн хоёрын гайхалтай харилцааг олж хардаг. 2:18-р ишлэлд, Ертөнцийн Эзэн Адаамд санаа тавьж, түүнд Хаваах хэмээх төгс хамтрагчийг өгсөн. Эндээс бид хүн Ертөнцийн Эзэнтэй ямар ойр дотно, амар тайван харилцаатай байсныг харж байна. Харин түүхийн гуравдугаар хэсэгт энэ дотно харилцаанд сэв суудаг. Эхлэл номын 3-р бүлэгт Адаам, Хаваах хоёр Ертөнцийн Эзэнд дуулгаваргүй хандаж: ...Түүнээс нуугдахад Ертөнцийн Эзэн тэр хоёрт уурладаг.

Хоёр дахь ялгаа нь хүний харилцаан дахь өөрчлөлт юм. 2:18-25 дахь хоёрдугаар хэсэгт Адаам, Хаваах хоёр төгс аз жаргалтай байсан. 2:23-т Адаам Хаваахыг “яснаас минь гарсан яс, махнаас минь гарсан мах” хэмээн хэлж байгаа нь Библи дэх анхны хайрын шүлэг юм. Тэд хамтдаа амьдарч, нүцгэн байсан ч бие биенээсээ ичдэггүй байсан. Харин 3:16-д Ертөнцийн Эзэн тэдний харилцааг харааж, тэдний хооронд үргэлж орших зөрчилдөөнийг тунхагладаг. Ийнхүү эмэгтэй нь эрэгтэйгээ хүсэмжилж, нөхөр нь эхнэрээ захирах болсон. Энэ үгс нь Адаам, Хаваах хоёрын хийсэн гэм тэдний зөвхөн Ертөнцийн Эзэнтэй харилцах харилцаанд нөлөөлөөд зогсоогүй, хоорондын харилцааг нь бас сүйтгэснийг харуулж байна. Тэр мөчөөс хойш хүмүүсийн харилцаанд үргэлж асуудал, бэрхшээл гарах болсон юм.

Гурав дахь ялгаа нь хүн төрөлхтөн ба ёрын муугийн хоорондын харилцаанд илэрч байна. Түүхийн хоёрдугаар гол хэсэгт ёрын муу гэдэг зүйл хүнээс хол хөндий байсан. Адаам, Хаваах хоёр гэм зэмгүй бөгөөд ёрын муугийн хүчнээс тусгаарлагдсан байв. Харин гуравдугаар хэсэгт хүн могойнд уруу татагдаж, ёрын муугаас болж үүрд шаналах болсон. 3:15-д Ертөнцийн Эзэн Хаваахын үр удам нэгэн өдөр могойг дийлнэ гэсэн боловч ойрын хугацааны ялалтын талаар хэлээгүй.

Уг хүүрнэлийн хоёр, гурав дугаар хэсгийн хоорондох эдгээр ялгаа нь Мөшэхийн хэлэхийг хүссэн хэд хэдэн санааг ойлгоход бидэнд тусална. Мөшэх Адаам, Хаваах хоёрын тухай бичсэн нь Израйльчуудын амьдралтай шууд холбогдож байлаа. Гэм тэдний амьдралыг сүйтгэн бусниулж, хүн ба Ертөнцийн Эзэний хоорондын харилцаа, мөн хүмүүсийн хоорондын харилцааг ч мөхөөж байв. Үүнээс гадна тэдний өдөр бүр үзэж байсан зовлон бэрхшээл нь тэд Ертөнцийн Эзэн



ёрын муугийн эсрэг ялалтыг өгөх үеийг Адаам, Хаваах хоёрын адилаар өдөр бүр хүлээх хэрэгтэй гэдгийг сануулж байлаа.

Утга зохиолын бүтцийг ийнхүү ойлгосноор бид энэ хэсгийн эх утгыг ойлгох боломжтой болж байна. Хүмүүс Ертөнцийн Эзэний цэцэрлэгээс хөөгдсөн тухай Мөшэх яах гэж бичсэн бэ? Израйлийн ард түмнийг амласан нутаг руу удирдан дагуулж явахдаа үүгээр дамжуулан юу ойлгуулахыг хүссэн юм бол оо?

## ЭХ УТГА

---

Ерөнхийд нь хэлэхэд Мөшэх өөрийн дагуулж явсан Израйлийн ард түмэнд зарим нэг ерөнхий теологийн ойлголтуудыг заахын тулд энэ хүүрнэлийг бичжээ. Тэр дэлхий дээрх гэмийн гарал үүсэл, мөн чанар, болон үр дагаврын тухай хэлсэн ба энэ бүхэн маш чухал ач холбогдолтой байв. Өмнөх хичээл дээр үзсэнчлэн Мөшэх балар эртний энэ түүхийг Израйльчуудад зүгээр л түүхэн теологийн асуудлуудыг мэдээлэхийн тулд бичээгүй. Харин бусад эртний бичээч нарын адилаар тухайн үеийн шашны болон нийгмийн асуудлууд буюу, энэ тохиолдолд Египетийг орхиж, Хинаан орон руу явахад хэрэгжүүлэх заавар өгөхийн тулд бичжээ.

Мөшэх эртний Ээдэн цэцэрлэг болон Израйльчууд Хинаан нутгийг эзэлсэн хоёр үйл явдлыг хэрхэн холбсоныг харахын тулд бид энэ түүхээс гурван элементийг харах болно: Нэгд, Ээдэн цэцэрлэгийн дүрслэл, хоёрт, Адаам, Хаваах хоёр үнэнч байхын тулд хангах ёстой шаардлагууд, мөн тэдний дээр буусан хараалыг хэрхэн дүрсэлснийг харна. Эхлээд Мөшэх Ээдэн цэцэрлэгийг яаж дүрсэлснийг харцгаая.

## ЦЭЦЭРЛЭГ

Мөшэхийн тодорхойлолт дэндүү нарийн төвөгтэй учраас одоог хүртэл Ээдэн цэцэрлэгийн талаарх зарим нэг асуулт хариулагдаагүй байдаг. Гэсэн хэдий ч Мөшэхийн гол санааг барьж авах боломжтой. Ээдэн цэцэрлэгийг хэрхэн тодорхойлсноос нь уг цэцэрлэгийг амлалтын нутагтай зүйрлүүлж байсныг мэдэж болно. Мөшэхийн харж байснаар ард түмнээ дагуулж байгаа нутаг балар эртний үеийн Ээдэн хэмээх газартай яг л адил байжээ.

Эхлэл 2-3 дээрх нэлээн олон хэсгээс бид Мөшэх Израйльчуудыг Хинаан орныг Ээдэнтэй зүйрлүүлж ойлгоосой гэж хүсч байсныг тодорхой харж болно. Харин энэ дундаас хоёр зүйл илүү чухал. Нэгдүгээрт, Ээдэн цэцэрлэгийн Онцлог, хоёрт, Ээдэний Ариун байдал. Эхлээд Ээдэний онцлогийг харья.

## Онцлог

Эхлэл 2:10-14-т,

Эдэнд урсаж ордог ганцхан мөрний ус цэцэрлэгийг усалдаг байлаа.

Ээдэнгээс гараад мөрөн гол дөрөв салаалан 11Пишон хэмээх эхний



салаа нь алтаар баян Хавилаах гэдэг нутгаар урсан өнгөрдөг байв...

Хоёр дахь салааг Гихун гэх ба Хүшийн бүх нутгаар дайрна. Гурав дахь салааг Тигр гэдэг бөгөөд энэ нь Ассири орны зүүн талаар урсдаг байлаа. Харин дөрөв дэхийг нь Евфрат гэнэ (Эхлэл 2:10-14).

Мөшэх Ээдэнээс эх авсан нэг гол Пишон, Гихун, Тигр болон Евфрат хэмээх дөрвөн голд салаалдаг гэсэн. Ийнхүү Ээдэнд урсан ордог гол нь энэ дөрвөн голыг тэтгэдэг байжээ. Уг дөрвөн голын төв эх үүсвэр нь энэ гол байв.

Мөшэхийн энэхүү дүрслэлийг харахдаа бид дэлхий анх бүтээгдсэнээс хойш газаргүйн хувьд маш олон өөрчлөлт болсон гэдгийг санах хэрэгтэй. Бүр Мөшэхийн үед эдгээр дөрвөн голыг тэтгэгч гол үгүй болсон байсан. Бичээс бидэнд усны эх үүсвэр болсон энэ гол төгсгөлийн үед л дахин бий болно гэдгийг хэлсэн байдаг. Харин Мөшэх ийнхүү ганц голоос эх авдаг дөрвөн голыг дурдсан нь тэр Ээдэн хэмээх нутаг газарзүйн хувьд хаана байсныг нь барагцаагаар харж болно.

2-р бүлгийн 13-14-т гарч буй Тигр, Евфрат мөрнийг өнөөгийн газарзүйн байршлаар нь тогтоож болно. Эхлэл номонд энэ дөрвөн голыг дурддаг нь Ээдэн цэцэрлэг Месопотамийн ойролцоо байдаг гэж үздэг Вавилоны домогтой санал нийлдэг хэмээн орчин үеийн зарим судлаачид хэлдэг. Вавилон хэлэнд Эдин гэдэг нь “тэгш тал нутаг, задгай тал” гэсэн утгатай байдаг нь Тигр, Евфратын нам дор газрыг яг дүрсэлж байгаа юм. Харин Еврей хэлээр Ээдэн гэдэг нь “тэгш тал” гэсэн үг биш, харин “таатай, сайхан газар” гэсэн үг. Мэдээж хэрэг Мөшэх Вавилон үг хэрэглээгүй нь лавтай. Тэгэхээр Ээдэн хэмээх үгийн Вавилон орчуулгатай адилхан сонсогддог үгийг ашигласан боловч, нэрнийх нь утга адилгүй байжээ. Харин үнэн хэрэгтээ, Ээдэн Месопотамиар хязгаарлагдаагүй гэдгийг Эхлэл номонд тодорхой хэлдэг. Эхлэл 2:10-т харсанчлан, Тигр, Евфрат хоёр Ээдэнд байрлах нэгэн том голоос эх авч байсан:

Ээдэнд урсаж ордог ганцхан мөрний ус цэцэрлэгийг усалдаг байлаа.

Ээдэнээс гараад мөрөн гол дөрөв салаалдаг байв (Эхлэл 2:10).

Энэ хэсгээс бид Ээдэний гол Тигр, Евфрат голуудад салаалдаг байснаас бус, бүх газар нутаг нь энэ хоёр голоор хязгаарлагддаг гэж хэлээгүйг харж байна. Мөшэх Ээдэний хамгийн зүүн захыг газарзүйн хувьд ерөнхийд нь тодорхойлохын тулд Тигр, Евфрат голуудыг дурдсан. Дорнодын эдгээр том голууд Ээдэний газар зүйн хязгаарыг тодорхойлж байна.

Эхлэл 2-р бүлэгт гарч буй бусад голын байршлаар Ээдэний ерөнхий хил хязгаарыг нь тодорхой харж болно. 2-р бүлгийн 11,13-р ишлэлд Мөшэх өөр хоёр голыг нэрлэдэг. Тэр хэлэхдээ Ээдэний гол “Хавилаахаар урсдаг” Пишон, “Хүшийн нутгаар урсдаг Гихуныг тэтгэдэг байсан гэжээ. Хуучин Гэрээнээс харвал Хавилаах болон Хүшийн нутгууд нь Египетийн газар нутагтай ойролцоо байсныг харж болно. Энэ хоёр гол Нил мөрөнгөөс хаана оршиж байсныг Мөшэх юу гэж хэлснийг бид мэдэх боломжгүй ч, Ээдэний баруун хэсэг нь одоогийн Египетийн хойд хэсэг болохыг тодорхой хэлж болно.

Мөшэхийн дүрслэн хэлснээр бол Ээдэн тийм ч жижиг газар биш байв. Харин Тигр-Евфратын газар нутгаас Египетийн хил хүртэл үргэлжлэх газар нутаг буюу

бидний одоогийн нэрлэдгээр нуман хэлбэртэй үржил шимт газар байжээ. Энэ сайхан нутагт Ээдэн хэмээх газрын төв болсон Ээдэн цэцэрлэг байрлаж байсан байна.

Ээдэнийг нуман хэлбэртэй үржил шимт газар байсан хэмээн тодорхойлох нь эхэндээ тийм ч чухал биш санагдаж болно. Харин Мөшэх Израйльд зориулж Эхлэл номыг бичихдээ Ээдэнд ямар ач холбогдол өгснийг ойлгох нь маш чухал. Эхлэл номын өөр нэг хэсэгт Мөшэх нуман хэлбэртэй үржил шимт нутаг Ээдэн бол Ертөнцийн Эзэний Израйльд амласан нутаг юм гэдгийг заахын тулд Эхлэлийн 2-р бүлэг рүү эргэн очдог. Эхлэл 15-р бүлэг, 18-р ишлэлд Ертөнцийн Эзэн Аврахаамд хэлсэн үгнээс энэ тухай харж болно. Амласан нутгийн хил хязгаарыг Ертөнцийн Эзэн хэрхэн тодорхойлсныг одоо харцгаая:

Тэр өдөр Мөнхийн Эзэн Авраамтай гэрээ тогтоож, ‘Энэ газар нутгийг би удам угсаанд чинь өгнө. Энэхүү газар нутаг нь Египетийн хил дээрх голоос эхлээд Евфрат мөрөн хүртэл үргэлжилнэ.’ (Эхлэл 15:18).

Эндээс бид Ертөнцийн Эзэн Аврахаамд түүний газар нутаг нь Тигр-Евфратын нутаг хүртэл үргэлжилнэ гэж амласныг харж байна. Мөн “Египетийн гол” хүртэл үргэлжилнэ гэжээ. Судлаачид “Египетийн гол” гэдэг нь Нил мөрөн биш, харин Египетийн хил дээр байрлах Синай уулаас эх авсан арай жижиг гол гэж ярьдаг. Энэ ишлэлд Ээдэний газар зүйн хил хязгаарыг Эхлэл номын 2-р бүлэгт дүрсэлсэнтэй ижлээр дүрсэлсэн байна. Эндээс харвал Ертөнцийн Эзэн Аврахаам болон түүний үр удамд эрт дээр үед Ээдэн хэмээн нэрлэгддэг байсан газар нутгийг амласан гэж Мөгөх итгэж байжээ. Мөшэхийн хэлж байгаагаар бол Израйльчуудын чиглэн явж байсан Хинаан орон нь үнэн хэрэгтээ балар эртний Ээдэний газар нутаг байв.

Израйльчууд Ээдэнийг зорьж байгаа гэдгийг чухалчлахын тулд Мөшэх энэ газрын ариун шинж чанарыг дурдсан байдаг. Израйльчууд Хинаанд очсоноор Ертөнцийн Эзэний онцгой оршихуйд орж, Түүний ивээлийг авна гэдгийг харуулахын тулд Мөшэх Ээдэний ариун шинж чанарыг онцлон хэлсэн байна.

## Ариун байдал

Ийнхүү Ээдэний ариун шинж чанарыг дурдахдаа Мөшэх Майхан сүмийг тодорхойлж байсан үгсээ голчлон ашигласан. Хэдийгээр Ертөнцийн Эзэн хаа сайгүй оршин байдаг ч гэсэн, Мөшэх Майхан сүмийг барьснаар Ертөнцийн Эзэн онцгой байдлаар Өөрийн хүмүүстэйгээ учрах болсон. Энэ Майхан сүмд Ертөнцийн Эзэн оршихуйгаа харуулж, хуулиа өгөн, хүмүүсийнхээ магтаал хүндэтгэлийг хүлээн авч, тэдэнд тааллаа үзүүлдэг байлаа. Мөшэх Майхан сүмийг тодорхойлсныхоо адилаар Ээдэн цэцэрлэгийг дүрслэн хэлэхдээ Ээдэн болон Хинаан орон нь энэ дэлхий дээрх Ертөнцийн Эзэний онцгой оршихуй мөн юм гэдгийг илчилж байв. Тэнд Израйльчууд Ертөнцийн Эзэний агуу ивээлүүдийг хүртэх боломжтой байжээ.

Ээдэн бол Майхан сүмийн адилаар Ертөнцийн Эзэний онцгой оршихуй бүхий ариун газар байсан гэдгийг харуулах дор хаяж 7 үзүүлэлт бий. Нэгдүгээрт, 3-р бүлгийн 8-р ишлэлд Мөшэх “Ертөнцийн Эзэн цэцэрлэг дундуур алхаж байсан” гэсэн хэллэгийг ашигласан байдаг. “Алхах” гэдэг үгийг Еврейгээр “миталээх” (יָלַךְ) гэдэг ба энэ хэллэг бол үнэхээр онцгой юм. Учир нь Майхан сүм дэх Ертөнцийн

Эзэний оршихуйг Левит номын 26-гийн 12 болон бусад хэсгүүдэд Мөшэх яг энэ үгээр дүрсэлсэн байдаг.

Хоёрдугаарт, 2-р бүлгийн 9-р ишлэлд Ээдэн цэцэрлэгийн гол онцлог болох амийн модны тухай гардаг. Энэхүү ариун мод жимсийг нь идсэн хүмүүст мөнхийн амьдралыг өгөх чадалтай байв. Сүүлийн үеийн археологийн судалгаанаас эрт дээр үед хүмүүс ариун газартаа мөнх амийг өгөгч модыг дуурайлган хийж бэлэгдэл болгон байрлуулдаг байсныг баталжээ. Энэ баримт нь Майхан сүмд байдаг байсан долоон лааны суурь бол амьдрал өгөгч модыг дүрслэн хийсэн бэлэгдэл болохыг харуулж байна. Тиймээс Ээдэн цэцэрлэг нь дэлхий дээрх ариун газар байжээ.

Гуравдугаарт, Мөшэх Ээдэний ариун байдлыг алт болон танан судалт гартаам эрднээр илэрхийлсэн. 2-ын 12-р ишлэлд Ээдэн нутагт алт, танан судалт гартаам элбэг байсан гэжээ. Мөн түүнчлэн Египетээс гарсан нь номын 25-40-р бүлэгт эдгээр эрдэнэс Майхан сүмийг барихад чухал үүрэг гүйцэтгэж байсныг харж болно.

Ээдэн цэцэрлэг, Майхан сүм хоёрын хоорондох дөрөвдүгээр холбоос бол эргэлдэн хөдөлж байдаг галт сэлэм бүхий ер бусын харуул юм. 3-р бүлэг, 24-р ишлэлд, Ертөнцийн Эзэн хүнийг мөнхийн амьдрал өгөгч модонд хүргэхгүйн тулд ер бусын харуул тавьсан гэж байдаг. Мөн “Египетээс гарсан нь” номын 25-ын 18, 37-ийн 9-р ишлэлд ийм ер бусын харуул Майхан сүмийг хамгаалж байсныг бас харж болно. Эдгээр харуул Израйльчуудад зөвхөн Мөнхийн Улсын ер бусын элч нар бус, харин Ээдэн хэмээх ариун газрыг хамгаалж байсан элч нарыг сануулж байв.

Тавдугаарт, Эхлэл 3-р бүлгийн 24-р ишлэлээс бид Ээдэний орох хаалга “зүүн зүгт” буюу зүүн талд нь байсныг уншиж болно. “Египетээс гарсан нь” 27-р бүлэг 13-р ишлэл болон өөр олон хэсэгт Майхан сүмийн хаалга мөн л зүүн талд нь байсан гэдгийг мэдэхээс нааш магадгүй энэ тийм ч ач холбогдолтой санагдахгүй байх. Эртний үеийн ихэнх сүмийн хувьд ийм байдаг байжээ. Дахин хэлэхэд Ээдэнд Ертөнцийн Эзэний ариун оршихуй байсан юм.

Зургаад, Мөшэх Адаамын Ээдэнд хийж байсан ажлыг Левит номын хаа нэгтээ Майхан сүм дэх үйлчлэлийг хэлсэн хэллэгээрээ тодорхойлсон. 2-р бүлгийн 15-р ишлэлд Мөшэх Адаамын үүрэг хариуцлагыг ингэж тодорхойлжээ:

Ертөнцийн Эзэний түүнийг Ээдэн цэцэрлэгт авчраад, цэцэрлэгийг арчлан харах үүрэг өгөв (Эхлэл 2:15).

Эдгээр үг хэллэг Тооллого номын 3-р бүлгийн 7-8, мөн 8-р бүлгийн 26-р ишлэлд давтагддаг бөгөөд Мөшэх Майхан сүмийн хувьд ч ижил хэллэгийг ашигласан байна. Адаам, Хаваах хоёр Ээдэн цэцэрлэгт тахилч хийдэг байв.

Долдугаарт, Ертөнцийн Эзэн Ээдэн цэцэрлэгийг 6 өдөр бусад зүйлийг бүтээснийхээ дараа бүтээсэн. Өмнөх хичээлд үзсэнчлэн Эхлэл номын 2-р бүлэг 1-3-р ишлэлд Ертөнцийн Эзэн зургаан өдөрт бүх зүйлийг бүтээгээд, долоо дахь өдрөө амарсан. Харин “Египетээс гарсан нь” 24-р бүлэг, 16-р ишлэлд мөн Мөшэх 6 өдөр уулан дээр Ертөнцийн Эзэнтэй байж байгаад, долоо дахь өдөр нь Майхан сүмийг барих зааврыг Ертөнцийн Эзэн түүнд өгдөг нь тун сонирхолтой.

Ээдэн цэцэрлэгийн эдгээр долоон үзүүлэлт нь Мөшэх энэ цэцэрлэгийг Майхан сүмийн адил ариун газар хэмээн үзэж байсныг харуулж байна. Энэ бол дэлхий дээрх Ертөнцийн Эзэний онцгой оршихуй байв. Мөн энэ газартай ойр байна гэдэг нь Түүний ивээлтэй ойр байна гэсэн үг байжээ.

Өмнө нь хэлсэнчлэн Мөшөх Эдэний газар нутгийг тэр үеийн Хинаан орон гэдэгт итгэж байсан. Тиймээс Эдэний ариун байдлыг онцолж байхдаа Хинааны ариун байдалд ч мөн анхаарлаа хандуулж байв. Хинаантай ойр байна гэдэг бол Ертөнцийн Эзэн ариунаар оршин байдаг газартай ойр байна гэсэн үг байжээ. Ирээдүйн энэ газрын тухай Мөшөх юм хэлснийг харах хамгийн тохиромжтой хэсэг бол Дэд хуулийн 12-р бүлэг, 10-11-р ишлэл юм. Тэр ингэж бичжээ:

Та нар Иордан голыг гаталж, Ертөнцийн Мөнх Эзэнийхээ өв болгон өгч буй газар нутагт суурьших болно. Тэр та нарыг бүх дайснуудаас чинь ангижруулах учраас та нар аюулгүй амьдарна. Дараа нь тэр газарт. Ертөнцийн Мөнх Эзэн чинь Өөрийн Нэрний оршихуйн төлөө байр сонгож, та нар тэнд миний тушаасан бүхнийг: шатаалт өргөл, тахил, аравны нэг болон онцгой бэлгүүд, мөн Мөнхийн Эзэндээ амласан бүх сонгомол эд хөрөнгүүдийг авчрах болно. (Дэд хууль 12:10-11).

Энэ хэсэгт Мөшөх Хинаан орныг хэрхэн харж байсан тухай чухал нэгэн үзүүлэлтийг харуулж байна. Нэгэн өдөр Хинаан орон Ертөнцийн Эзэний байнгын оршихуй, Яахвэхийн сүм болно гэдгийг тэр онцолжээ. Мөшөхийн үеийн Хинаан орон бол Эдэн цэцэрлэгийн дэргэд сүүдэр төдий л газар байсан юм. Шиломох хаан Иерусалимд сүм барих үед ч амласан газар гэмтэй хэвээрээ, төгс төгөлдөр байдалдаа буцаж ороогүй байсан. Харин Эдэний ариун байдлын тухай бичихдээ Мөшөх Израйльчуудад амласан газрын хожмын нэг өдрийн дүр зургийг өгч байв. Амласан нутагт хүрнэ гэдэг нь Эдэний бүс нутаг буюу Ертөнцийн Эзэний энэ дэлхий дээрх ариун оршихуй руу чиглэж буй хэрэг байлаа. Ертөнцийн Эзэн Адаам, Хаваах хоёрыг үзэсгэлэнт цэцэрлэгт анх аваачсан шиг, Израйлийг Хинаан орон руу авчирч байсан ба тэнд амьдарснаар Израйль үндэстэн Ертөнцийн Эзэний онцгой оршихуйд байж, Түүний ивээлүүдийг авах байв.

Мөшөх Эдэн дэх Адаам, Хаваах хоёрын эдэлж байсан ивээлийг амласан газарт Израйльчуудыг хүлээж буй хайр ивээлийн жишээ болгон ашигласан гэдгийг харлаа. Одоо Эхлэл номын 2-3-р бүлэг дэх хоёрдугаар гол сэдэв болох Ертөнцийн Эзэн Адаам, Хаваах хоёрын үнэнч байдлыг шалгасан тухай үзье. Энэ санаа Мөшөхийн зорилгод маш чухал үүрэг гүйцэтгэж байна.

## ҮНЭНЧ БАЙДАЛ

Үнэнч байх гэсэн сэдэв Мөшөхийн бичсэн Эдэний түүхэнд маш чухал байсан юм. Хэдийгээр Эдэн нь гайхалтай ивээлээр дүүрэн газар байсан ч гэсэн, Ертөнцийн Эзэн энд бас ёс суртахууны хувьд асар өндөр хариуцлагатай байхыг шаарддаг байсан. Израйльчууд очихоор зорьж байгаа амласан газарт Ертөнцийн Эзэний тушаалд үнэнч байх хэрэгтэй гэдгийг сануулахын тулд Мөшөх энэ тухай бичжээ.

Мөшөх энэ сэдвийг яагаад хөндсөнийг ойлгохын тулд бид хоёр асуудлыг авч үзэх хэрэгтэй. Эдэн цэцэрлэг дэх үнэнч байдал болон Хинаан дахь үнэнч байдал.

Эхлээд Ээдэн цэцэрлэгт Ертөнцийн Эзэн Адаам, Хаваах хоёроос ямар үнэнч байдлыг шаардаж байсныг харцгаая.

## Ээдэнд

Эхлэл номын 2-р бүлгийн эхэнд Ээдэн цэцэрлэгт байхын тулд хэрхэн үнэнч байх ёстой тухай анх гардаг ба 2,3-р бүлэгт дахин дахин давтагддаг. Энэ сэдэв бол 2,3-р бүлгүүдийн гол санаа юм. Эхлэл 2-р бүлгийн 16-17-р ишлэлд Ертөнцийн Эзэн хэрхэн Адаамыг үнэнч байдалд уриалсан болохыг харъя:

Чи энэ цэцэрлэгийн аль ч модноос идэж болно, харин сайн мууг таниулагч модноос идэж болохгүй, хэрэв идвэл тэр дороо үхэх болно (Эхлэл 2:16-17).

Ертөнцийн Эзэн бидний өвөг дээдсийг энэ модонд хүрэхийг хориглосон гэдэг нь бүхэлдээ тийм ч тодорхой биш. Үнэн хэрэгтээ Библийн бусад хэсгүүдэд сайн, мууг ялган таних нь шагнууштай зүйл гэсэн байдаг. Харин Ертөнцийн Эзэн Адаам, Хаваах хоёрыг Түүнд үнэнч байх эсэхийг нь шалгасан. Хэрэв тэд дуулгавартай байвал илүү агуу ивээлүүдийг авах байсан. Харин дуулгаваргүй хандвал Ертөнцийн Эзэн тэднийг шийтгэх ёстой. Ээдэн ариун газар байсан учраас, тэнд амьдарч буй хүмүүс ч ариун байх ёстой байсан юм.

## Хинаанд

Мөшэх Израйльчуудыг удирдан дагуулж явахдаа Ертөнцийн Эзэн тэднийг Өөрт нь үнэнч итгэлтэй байхыг шаардаж байгааг дахин дахин сануулдаг байсан. Энэ санаагаа тэр Дэд хууль номын 8-р бүлэгт товчоор дурдсан байдаг. Уг номын 8-р бүлэг, 1-р ишлэлд ингэж бичсэн байна:

Өнөөдөр миний та нарт өгч буй тушаал бүрийг ёсчлон дага. Тэгвэл та нар амьдран, өнөр өтгөн болж, өвөг дээдэст чинь Мөнхийн Эзэний амласан тэр газарт орж, эзэмшинэ (Дэд хууль 8:1).

Энэ хэсгээс харахад Израйльчууд Хинаан орны амласан газарт орохын тулд Ертөнцийн Эзэн тэднийг Өөрт нь үнэнч байхыг шаардаж байсан нь харагдаж байна. Үнэндээ Израйль үндэстэн цөлөөр тэнүүчилж явсан бүх хугацаанд Ертөнцийн Эзэн тэдэнд хэрхэн ариун амьдрахыг зааж байв. Харин 8-р бүлгийн 2-р ишлэлд:

Ертөнцийн Мөнх Эзэн чинь та нарыг энэ дөчин жилийн турш хэрхэн цөлөөр дагуулж явсныг сана. Энэ нь та нарын зүрхэнд юу байгааг, Түүний тушаалыг дагах эсэхийг мэдэхийн тулд, та нарыг даруу болгож, шалгахын тулд байсан юм (Дэд хууль 8:2).

Үүнээс гадна Мөшэх Израйль үндэстэн ариун газарт нэгэнт ирсэн бол Ертөнцийн Эзэнд үнэнч байх хэрэгтэй, эс тэгвэл тэд энэхүү хувь тавиланг алдана гэдгийг тодорхой хэлсэн. Энэ тухай хэрхэн хэлснийг Дэд хууль номын 8-р бүлгийн 10-20-р ишлэлээс харъя:

Та нар хоол идэж цадахдаа сайхан газар өгсөнийх нь төлөө Ертөнцийн Мөнх Эзэнээ магт. <sup>11</sup>Өнөөдөр миний та нарт өгч байгаа Түүний тушаал, хууль, зарлигийг дагалгүй Ертөнцийн Мөнх Эзэнээ мартахаас болгоомжил... Хэрэв та нар Ертөнцийн Мөнх Эзэнээ мартаж, өөр бурхдыг даган, тэднийг хүндэлж, мөргөвөл та нар гарцаагүй сүйрэх болно гэж би өнөөдөр та нарын эсрэг гэрчилж байна. Та нарын өмнөөс Мөнхийн Эзэний тань устгасан үндэстнүүдийн адилаар та нар Ертөнцийн Мөнх Эзэнээ дагаагүйнхээ төлөө устгагдах болно (Дэд хууль 8:10-20).

Израйльчууд Адаам, Хаваахын адилаар Ертөнцийн Эзэний тушаалыг зөрчих хандлагатай байгааг Мөшэх мэдэж байв. Тийм ч учраас тэр Ертөнцийн Эзэн Хинаан оронд амьдрахыг хүссэн хүн бүрийг үнэнч байхыг шаарддаг гэдгийг анхааруулахын тулд Адаам, Хаваах хоёр цэцэрлэгт байхдаа хэрхэн соригдож байсныг онцолсон юм. Мэдээж хэрэг Ертөнцийн Эзэн Израйлийг төгс бай гэж шаардаагүй, харин хүн бүр Түүний хайр энэрлийн улмаас үнэнч үлдэх боломжтой байсан. Хэрэв Израйльчууд ичгүүртэйгээр Ертөнцийн Эзэний хуулийг зөрчиж, Түүнээс нүүр буруулбал Адаам, Хаваах хоёрын адилаар амласан газрын ивээлүүдийг хүртэх эрхгүй болох байв. Ийнхүү Мөшэх Израйлийг амласан нутаг руу урагшлахыг уриалахдаа тэнд очоод үнэнч байдлыг амьдралынхаа чухал хэсэг болгох ёстой гэдгийг санаасай хэмээн хүсч байжээ.

Дэд хуулийн 8-р бүлгээс үзсэн зүйлээ санангаа, бид одоо Мөшэх яагаад Адаам, Хаваахын үнэнч байх ёстойд анхаарлаа хандуулсныг харж болно. Тэр Израйлийн ард түмнийг Адаам, Хаваахын хийсний эсрэгээр Ертөнцийн Эзэний тушаалд дуулгавартай байж, хийсэн алдааг нь давтахгүй байхад уриалахын тулд энэ асуудлыг хөнджээ. Адаам, Хаваах хоёр цэцэрлэгт байхдаа соригдож, сорилтыг даалгүй гэм хийсэн учраас тэндээс хөөгдсөн. Мөшэхийн үед Израйльчууд цэцэрлэгийн гадна талд хэвээр байсан боловч тэднийг дахин Эдэнд орж, ивээгдэж амьдрахад нь бэлдэхийн тулд Ертөнцийн Эзэн тэднийг ийнхүү сорьж байлаа.

Бид Мөшэх Израйльчуудад олон жилийн өмнө Адаам, Хаваахын үед юу болсон тухай тайлбарлахын тулд л Эдэн цэцэрлэг дэх үнэнч байдлын тухай бичээгүй гэдгийг харлаа. Харин тэр өөрийнх нь үед юу болж байгаа тухай бичсэн. Ертөнцийн Эзэн Израйльд Эдэн цэцэрлэгийн гайхамшигт ивээлүүдийг санал болгосон. Харин хэрэв тэд Ертөнцийн Эзэн үнэнч байхгүй бол Адаам, Хаваахын адилаар уг ивээлүүдийг хүртэж чадахгүй байв. Мөшэх Израйльчуудыг Ертөнцийн Эзэний тушаалд өөрсдийгөө бүрэн зориулж, ариун хүмүүсийн адилаар итгэлээрээ амьдрахад дуудаж байжээ. Зөвхөн ингэж байж л тэд амласан газарт орж, тэндээ амар тайван байна хэмээн найдаж болох байсан юм.

Бид сая Мөшэх хэрхэн Эдэн болон Хинаан орныг Ертөнцийн Эзэний энэ дэлхий дээрх оршихуй болон ивээлүүдийн ариун газрын төлөөлөл хэмээн тодорхойлсныг харлаа. Мөн энэ хоёр газар нутагт амьдрахын тулд үнэнч байх ёстой



гэсэн санааг ч мөн харсан. Одоо бид Эхлэл номын 2,3-р бүлэг дэх гуравдугаар асуудалд анхаарлаа хандуулъя. Энэ бол Адаам, Хаваах хоёрын дуулгаваргүй байдал юм.

## ҮР ДАГАВАР

Ээдэн цэцэрлэг дэх үнэнч бус байдлын үр дагаврыг харахын тулд Адаам, Хаваах хоёрын хийсэн гэмийн гурван үр дүнг харах болно: эдгээр нь үхэл, өвчин зовлон болон цэцэрлэгээс хөөгдсөн явдал юм.

### Үхэл

Нэгдүгээрт Мөшэх Ертөнцийн Эзэн Адаам, Хаваахын хийсэн гэмээс болж тэдэнд үхэл заналхийлэх болсон тухай тайлбарласан. Ертөнцийн Эзэн Адаамд энэ тухай хамгийн анх Эхлэл номын 2-р бүлгийн 17-р ишлэлд анхааруулдаг. Тэр хэлэхдээ:

“Чи сайн мууг таниулагч модноос идэж болохгүй, хэрэв идвэл тэр дороо гарцаагүй үхнэ” (Эхлэл 2:17).

“Гарцаагүй үхнэ гэсэн” гэсэн өгүүлбэр нь хожим гарцаагүй ирэх үхлийг хэлж байгаа юм. Энэ өгүүлбэрийн дүрмийн бүтэц нь Мөшэх хуулийг дагаагүй хүн үхэх шийтгэлтэй гэж хэлэхдээ ашигласан бүтэцтэй тун адил байна. Мөшэхийн бичиж үлдээсэн хуулинд ноцтой гэмт хэрэг хийсэн хүмүүст хандан “тэр гарцаагүй үхэх болно”, эсвэл “тэд гарцаагүй үхэх болно” гэсэн байдаг. Хуулийн үүднээс авч үзвэл үхэх ял оноохдоо яг ийм бүтцээр хэлдэг байжээ. Ертөнцийн Эзэн Адаам, Хаваах хоёрыг тэр дороо үхнэ гэж хэлээгүй, харин гэмийг заавал үхэл дагадаг гэж хэлсэн байна.

Ийм учраас Эхлэл номын 2-р бүлгийн 17-р ишлэлд Ертөнцийн Эзэн Адаамд үхлийн ял тулгасан гэж ойлгох хэрэгтэй. Тэр үхэх ялаар шийтгүүлсэн юм. Мөшэх энэ дэлхийд үхэл хэрхэн орж ирсэн тухай тайлбарлахын тулд Адаамын гэмийн үр дагаврыг ийнхүү тодорхой тайлбарласан нь үнэн боловч, түүний зорилго нь энэ явдлыг Израйльчуудын амьдралтай шууд холбох явдал байсан юм. Тэд үхлийн талаар сайн мэддэг байсан. Мөшэхийн хуулийг уншигчид Египетээс гарсан эхний үеийнхний ихэнх нь Ертөнцийн Эзэнийг тэрсэлснээсээ болж цөлд нас барсан гэдгийг мэдэж байв. Тооллого 26-р бүлгийн 65-р ишлэлд Мөшэх бичсэнчлэн:

Мөнхийн Эзэн тэдэнд Иефунаахын хүү Калев, Нуны хүү Ешуугаа нараас бусад нь бүгд цөлд гарцаагүй үхэх болно гэж Израйльчуудад хэлсэн (Тооллого 26:65).

Мөшэхийн бичсэн хууль болон Ээдэн цэцэрлэгт Адаам, Хаваахын сонссон “Гарцаагүй үхнэ” хэмээх хэллэгийг бид энд дахин харж байна. Ийнхүү Адаам, Хаваахын түүхийг сонссон Израйльчууд цөлд үзсэн үхлийг Адаам, Хаваах хоёр



Ертөнцийн Эзэний тушаалыг зөрчихөд болсон явдалтай холбож ойлгож чадах байв. Ээдэн цэцэрлэгт үнэнч бус байсан хүн төрөлхтний анхны өвөг үхэх ялыг авч байсан бол Мөшэхийн үеийн Израйльчууд ч мөн үнэнч бус байдлыг үзүүлбэл адилхан үхэх ялыг сонсох байсан юм.

## Өвчин зовлон

Эхлэл номыг уншаад бид Адаам, Хаваах хоёр тэр дороо үхээгүй гэдгийг мэдэж болно. Ертөнцийн Эзэн Адаам, Хаваах хоёрт эхлээд өвчин зовлонг үзүүлсэн юм. Эхлэл 3-р бүлгийн 16-р ишлэлд ийм үг байдаг:

Чи жирэмсэн болохдоо олон янзын зовиуртай болж, үр хүүхэд төрүүлэхдээ маш их өвдөж зовдог болно (Эхлэл 3:16).

Мөн түүнчлэн Ертөнцийн Эзэн Адаамын амьдралд ч зовлонг өгсөн. Эхлэл номын 3-р бүлгийн 17-р ишлэлд бид Адаамд хандан хэлсэн дараах үгийг уншиж болно:

Чамаас болж газар шороо хараагдаж, чи хоолоо олж идэхийн тулд насан туршдаа зүтгэх болно (Эхлэл 3:17).

Ээдэн цэцэрлэг дэх гэрийн үр дагаврын тухай Мөшэхийн хэлсэн бүх зүйлээс хүний өвчин зовлонгийн талаарх дээрх хоёр зүйл түүний Израйльчуудад хандан энэ бүхнийг бичсэн зорилгыг тодорхой харуулж байна. Израйльчууд Хинааны гадна байхдаа дээр дурдсан өвчин зовлонг үзэж байсан юм. Одоо харин Мөшэх амласан нутаг дахь амьдралыг хэрхэн тодорхойлсныг харъя.

Дэд хууль 11:10-12-т:

Та нарын эзэмшихээр явж байгаа газар нутаг бол та нарын гарч ирсэн Египет оронтой адилгүй. Тэнд та нар үр тариад ногооны талбай услах мэт хөлөөрөө явж усалдаг байсан. 11 Харин Иордан голыг гатлаад та нарын эзэмших газар нутгийн уул, тал нь тэнгэрээс орох бороогоор ундаалдаг. 12 Энэ бол Ертөнцийн Мөнх Эзэний чинь асран хамгаалдаг газар бөгөөд жилийн эхнээс төгсгөл хүртэл Түүний нүд энэ газрыг харж байдаг (Дэд хууль 11:10-12).

Товчоор хэлэхэд Израйльчуудын Хинаан орноос гадна байхдаа амссан өвчин зовлон нь тэнд очоод тайлагдах байв. Мөшэх Адаам, Хаваах хоёрт ирсэн өвчин зовлонгийн тухай бичихдээ Израйль уншигчид нь өвчин зовлонгийн үндэс болсон үнэнч бус байдлаас болгоомжилж Мөнхийн Эзэндээ итгэмжтэй байхыг уриалжээ. Ингэснээр тэд Хинаан оронд очиж, Ертөнцийн Эзэний ивээлийн доторх амьдралын баяр хөөрийг мэдрэх байв.

## Цэцэрлэгээс хөөгдсөн нь

Адаам, Хаваах хоёр үнэнч бус байснаас болж гарсан гурав дахь үр дагавар Эхлэлийн 3-р бүлгийн 22-р ишлэлд гардаг:

Тэгээд Ертөнцийн Мөнх Эзэн, “За одоо энэ хүмүүс бидний адил сайн мууг таньж мэддэг боллоо. Үүнээс гадна тэр гараа сунгаж амьдрал өгөх модноос жимс авч идээд мөнх амьдарч болохгүй (Эхлэл 3:22).

Эндээс харвал хүн амьдрал өгөх модноос идэж “мөнх амьдрах” боломжтой байжээ. Энэ бол өвчин зовлон болон үхлийн талаарх хамгийн сүүлийн хариулт байлаа. арин Ертөнцийн Эзэн Адаам, Хаваах хоёрыг энэ модноос идэхийг хүсээгүй учраас тэднийг Эдэн цэцэрлэгээс хөөгдөж, амьдрал өгөх модонд хүрэх боломжгүй болсон. Гэхдээ бид хүн амьдралын модонд хүрэхээс үүрд мөнхөд хориглогдоогүй гэдгийг санах нь чухал. Бичээсийн үлдсэн хэсэгт Ертөнцийн Эзэнд үнэнч итгэлтэй байсан хүмүүс хожмын нэг өдөр энэ модноос идэх боломжтой болно гэж тодорхой хэлдэг. Энэ модны талаар Төлөөлөгч Иоган Үзэгдэл номын 2-р бүлгийн 7-р ишлэлд юу гэж хэлснийг харъя:

Бүхнийг тэсвэрлэж туулсан хүнд би Ертөнцийн Эзэний аз жаргалтай цэцэрлэг дэх амьдралын модноос идэх эрхийг өгнө (Үзэгдэл 2:7).

Иоган Есүс Христийн энэ дэлхийд дахин ирэх төгсгөл үеийн тухай ярьж байсан. Гэхдээ түүний энэ үгс Мөшэх яагаад Израйльчуудад амьдралын модны тухай бичсэнийг тайлбарлаж байна. Адаам, Хаваах хоёр гэм хийхэд Ертөнцийн Эзэн амьдралын модонд хүрэх замыг нь тагласан. Харин Мөшэхийн үед Ертөнцийн Эзэн Израйльчуудад Хинаан орон дахь ивээлээр дүүрэн амьдралыг дор хаяж амсах үүд хаалгыг нээж өгч байв. Энэ тухай Мөшэх Дэд хуулийн 30-р бүлгийн 19, 20-р ишлэлд хэрхэн хэлснийг харъя:

Өнөөдөр Би тэнгэр газрыг гэрч болгон дуудаж та нарын өмнө амьдрал ба үхэл, ерөөл ба хараалыг тавьж байна. Та нар болон та нарын үр удам амьдрахын тулд амьдралыг сонгож, Ертөнцийн Мөнх Эзэнээ хайрлан, Түүний дуу хоолойг сонсож, Түүнээс зуур. Учир нь Мөнхийн Эзэн бол та нарын амьдрал бөгөөд Тэр та нарын өвөг дээдэс Аврахаам, Яйцхаах, Яахобт өгнө хэмээн амласан газар нутаг дээр та нарт олон жил амьдрах боломжийг өгөх болно.” (Дэд хууль 30:19-20).

Хэрэв Израйльчууд Ертөнцийн Эзэнд үнэнч итгэлтэй байвал Хинаан оронд урт удаан бөгөөд аз жаргалтай амьдрах байлаа.

Адаам, Хаваах хоёр амьдралын модонд хүрэх эрхээ хасуулсны адилаар Мөшэхийн үед Ертөнцийн Эзэн Израйльчуудад амласан газар дахь амьдралын захаас зөвхөн амсуулж байлаа. Энэ амьдрал нь Есүс Христ дахин ирэх үед бидний үзэх мөнхийн амьдралтай зүйрлүүлэшгүй юм. Гэсэн хэдий ч Есүс Христийг ирэх үеийн тэр амьдрал тэндээс амтагдаж байв. Мөшэх Израйль үндэстэнд амласан газарт эдлэх урт удаан амьдралын ивээлийг санал болгож байжээ.

Адаам, Хаваах хоёр Ээдэн цэцэрлэгт байхда Ертөнцийн Эзэнтэй тэрсэлсэн тухай түүх нь зүгээр л гэм хэрхэн хүмүүсийн дунд орж ирснээс илүү том зүйлийн тухай гэдгийг бид харлаа. Ээдэнийг Хинаан оронтой холбосноор Мөшэх Израйльчуудад тэдний амьдралын тухай зааж өгч байв. Амласан нутаг тэдний хувьд хэр гайхалтай байхыг тэд ийнхүү мэдэж авчээ.

Бид сая Эхлэл 2-3-р бүлгийн утга зохиолын бүтэц болон эх утгыг олж харлаа. Одоо гурав дахь асуултандаа орьё. Хуучин Гэрээний энэ хэсгийг өнөөдөр хэрэгжүүлэх тухай Шинэ Гэрээнд юу гэж заадаг вэ?

## ОРЧИН ҮЕИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

---

Мөшэх энэ түүхийг Израйль үндэстнийг Адаам, Хаваахын алдааг давталгүйгээр Хинаан оронд орж, аз жаргалыг дахин олж авахад уриалахын тулд бичсэн гэдэг нь ойлгомжтой байна. Тэгвэл Израйльчуудад зориулсан энэ заавар өнөөдөр бидэнд ямар хамаатай вэ? Мөшэх цэцэрлэг дэх гэмийн тухай бичихдээ Израйльчуудыг Адаамын явсан замаар эргэн явж, хийсэн алдааг нь давтахгүй байснаар аз жаргалыг дахин олоосой гэж хүссэн. Үүний адилаар Шинэ Гэрээг бичсэн хүмүүс ч гэсэн Христийн аврал бол аз жаргалыг дахин олох явдал гэжээ.

Бид Христийн хаант улсын гурван үе шатын талаар үзэж, Шинэ Гэрээнд Эхлэл номын 2-3-р бүлгийг хэрхэн ашигладаг болохыг харах болно. Эхлээд Хуучин Гэрээний энэ хэсэг Христ анх ирэх үе буюу Христийн хаант улсын эхлэлтэй хэрхэн холбогдож байгааг харна. Дараа нь өнөөдрийн Ертөнцийн Эзэний хаант улсын үргэлжлэл буюу өөрсдийн амьдралтай холбож үзээд, эцэст нь Шинэ Гэрээнд Христ хоёр дахь удаагаа ирэх үе буюу Түүний хаант улсын төгсгөлтэй дээрх хэсэг ямар хамаатай болохыг судлах болно. Одоо Христийн хаант улсын эхлэлийг авч үзье.

### ЭХЛЭЛ

Шинэ Гэрээнд Есүс Христийн энэ дэлхий дээрх үйлчлэлийн талаар бичиж, Түүний хүн төрөлхтөнд авчирсан авралыг танилцуулсан байдаг. Хаант улсынхаа эхэн үед Есүс Адаам, Хаваах хоёрын явсан замаар явж, Ээдэнд хийсэн алдааг нь залруулсан. Энэ дэлхий дээр үйлчилж байхдаа Христ Адаам, Хаваахын биелүүлж чадаагүй Ертөнцийн Эзэний тушаалыг биелүүлсэн юм. Шинэ Гэрээнд гардаг энэ сургаалыг бид эхлээд Пуулийн захидлуудыг харж, дараа нь Матайн бичсэн сайн мэдээнээс судлах болно. Эхлээд Пуулийн үзэл бодлыг харцгаая.

### Пууль

Р Ром номын 5-р бүлгийн 14-р ишлэлд Пууль өөрийн үзэл бодлоо маш тодорхой илэрхийлсэн байна. Тэр бичихдээ:

Ийнхүү Адаамаас эхлээд Мөшэхийн үеийг хүртэл Ертөнцийн Эзэний үгийг анхны хүн Адаамын адилаар зөрчсөн хүмүүс болон, хуулийг зөрчөөгүй хүмүүсийг хүртэл үхэл ноёрхож байв. Адаам ба хожим ирэх Нэгэний хооронд төстэй тал бий (Ром 5:14).

Пууль Адаамыг хожим ирэх Нэгэнтэй төстэй гэж хэлснийг анзаараарай. Ромын 5-р бүлгийн үлдсэн хэсэгт тэрхүү “хожим ирэх Нэгэн бол” Христ гэдгийг тодорхой хэлдэг. Энэ тухай Ром 5-ын 18-19-р ишлэлд товчоор хэлсэн байдаг:

...нэг хүний хийсэн гэм бүх хүнд буруутгалыг авчирсны адилаар, нэг хүний зөв шударга байдлын улмаас хүн бүр гэмгүйд тооцогдож, шинэ амьдралыг авч болно. Нэг хүний дуулгаваргүй байдлаас болж олон хүн гэмтэйд тооцогдсон бол, нэг хүний дуулгавартайгаас болж олон хүн зөв шударгад тооцогдоно (Ром 5:18-19).

Пууль энд хэрхэн хэлснийг хараарай. Адаамын хийсэн “нэг гэм”-ээс болж “хүн бүрт буруутгал”-ыг авчирсан бол, Христийн “нэг зөв шударга үйлдэл” “бүх хүнд” “цагаатгалыг” авчирсан. Яагаад? Яагаад гэвэл Адаам хэмээх “ганц хүний дуулгаваргүй байдлаас” болж бид “гэмтэй”-д тооцогдсон. Харин Христ хэмээх “нэг хүний дуулгавартай байдлаас” болж бид “зөв шударгад” тооцогдсон.

Энэ сургаалыг ихэнх Христэд итгэгчид сайн мэддэг. Эхлэл 2-3-р бүлэгт Мөшэхийн хэлснээр Адаам хэмээх ганц хүний хийсэн үйлдлийн үр дагаврыг бүх хүн төрөлхтөн амссан. Адаам Ертөнцийн Эзэний өмнө хүн төрөлхтнийг төлөөлж байсан учраас түүний гэм бүх хүнд үхлийг авчирсан. Тэр гэмийн улмаас бид Ертөнцийн Эзэний ивээл бүхий аз жаргалтай газрын гадна, үхэл гэдэг хараалын доор төрсөн юм. Харин Шинэ Гэрээнд Есүс Христ бол Өөрт нь итгэсэн хүн бүрийг Ертөнцийн Эзэний өмнө төлөөлдөг гэсэн байдаг. Адаамын дуулгаваргүй байдлын эсрэгээр Есүс Христ Ертөнцийн Эзэний өмнө дуулгавартай байсан учраас энэ нь Түүнтэй нэгдсэн хүн бүрт зөвтгөл, амь амьдралыг авчирсан билээ.

Энэ сургаалаас бид Адаамын гэм хийсэн түүхийг амьдралдаа хэрэгжүүлэх талаар чухал зүйлийг сурч болно. Алдагдсан аз жаргалыг дахин олон цорын ганц зам бол Христийн зөв шударга бөгөөд дуулгавартай байдал юм. Бид өөрсдийн хийсэн үйлсээс болж аврагдан, аз жаргалыг олж чадахгүй. Харин бидний өмнөөс тэр аз жаргалыг авах төгс төгөлдөр хэн нэгэн биднийг төлөөлөх хэрэгтэй. Тэрхүү төлөөлөл бол Есүс Христ юм. Есүс Христ Аавдаа бүрэн дуулгавартай байсан учраас л бид аврагдан, мөнхийн амьдралыг авч, Ертөнцийн Эзэний оршихуйд орж чадна. Есүс энэ дэлхий дээр үйлчилж байхдаа төгс аз жаргал бүхий тэр газарт орох эрийг авсан бөгөөд зөвхөн Түүнд итгэсэн хүмүүс л Түүний хамт тийш орж чадна.

Шинэ Гэрээг бичилцсэн бусад хүмүүс ч мөн Пуулийн адилаар Адаам, Христ хоёрыг адилтгасан байдаг.

## Матай

Матай номын 4-р бүлгийн 1-11-р ишлэл дэх Есүсийн уруу татагдсан хэсэгт Матай онцгойлон Есүс хэрхэн Адаамын явсан замаар эргэн явж, түүний алдааг залруулсанд анхаардаг (Үүнтэй адил жишээ Луухын 4-р бүлгийн 1-13-т бий).

Есүс Христийн цөлд уруу татагдсан түүх Адаам, Хаваах хоёрын Ээдэн цэцэрлэгт байхдаа үзсэн зүйл болон, Мөшэхийн Израйльчуудад өгсөн хүнд сорилттой олон талаараа адил байна. Есүс Христ уруу татагдах үедээ байсан газар нь Израйльчуудын Мөшэхийг дагаж явах үедээ байсан газартай холбоотой. Матай 4-ийн 1-т, “Ариун Сүнс Есүсийг удирдан, цөлд аваачлаа” гэж байдаг нь Ертөнцийн Эзэн Израйлийг цөл рүү дагуулсантай адил байна. Ертөнцийн Эзэн Израйльчуудыг Өөрт нь дуулгавартай байх эсэхийг цөлд шалгасан. Есүсийг ч мөн цөлд шалгасан билээ.

Хоёрдугаарт, Есүсийн цөлд өнгөрүүлсэн хугацаа Израйлийн цөлд байсан хугацаатай мөн төстэй байн. Израйльчууд дөчин жил цөлд байсан бол Матай 4-ийн 2-т байгаачлан Есүс дөчин өдрийг цөлд өнгөрөөжээ.

Гуравдугаарт, Есүс Христ уруу татагдаж байхдаа өлсөж байсан. Матай 4-ийн 3-т адгийн муу ёрын сүнс Есүсийг чулууг талх болго гэж хэлдэг. Үүнийг Израйльчууд цөлд байхдаа ус, хүнсээр гачигдаж байсантай жишиж болох юм.

Дөрөвдүгээрт, Есүс өөрөө Бичээсээс иш татан ашиглахдаа өөрийн амьдралыг Израйлийн цөлд үзсэн шалгалттай холбодог. Матай 4-ийн 4-р ишлэлд Есүс Дэд хуулийн 8-р бүлгийн 3-ыг иш татдаг. Мөн Матай номын 4-ийн 7-д Дэд хуулийн 6-н 16-г, Матай 4:10-т Дэд Хуулийн 6-н 13-ыг иш татсан байдаг. Хуучин Гэрээний энэ бүх хэсэгт Мөшэх Израйльчуудын цөлд үзсэн шалгалтын талаар бичсэн байдаг. Ийнхүү иш татсанаараа Есүс өөрийн цөлд соригдсоныг Израйль үндэстний үзсэн сорилготой холбосон байна.

Матай Есүсийн уруу татагдсаныг Мөшэхийн Эхлэл 2-3-т Израйльчуудад зориулан бичсэн түүхтэй холбосныг бид сая харлаа. Есүс дуулгавартай байснаараа Адаам болон Израйльчуудын хийж чадаагүйг гүйцээсэн юм. Есүс Христ ийнхүү Ертөнцийн Эзэний тушаалуудад үнэнч байсан. Ийм ч учраас Есүс Луух 23:43-т байдаг алдарт үгсээ хэлсэн юм. Израйльчууд аз жаргал бүхий Хинаан оронд орохын тулд бэлдэж цөлд зовлон зүдгүүрийг үзсэн. Үүнчлэн Есүс загалмай дээр байхдаа гэмээсээ эргэсэн хулгайчид дараах үгийг хэлсэн:

I Би чамд чин үнэнийг хэлж байна, өнөөдөр чи надтай хамт Мөнхийн Улсад орох болно (Луух 23:43).

Есүс Христ түүнийг үүрдийн аз жаргалаар шагнасан.

Шинэ Гэрээнд Адаам, Хаваахын үзсэн уруу таталт, Израйлийн цөлд үзсэн шалгалтыг Есүс Христийн энэ дэлхий дээрх үйлчлэл буюу Түүний хаант улсын эхлэлтэй холбогдож байгааг харлаа. Христ бол эхний Адаамын алдсаныг амжилттай давсан сүүлийн Адаам юм. Мөн түүнчлэн, Есүс Христ Израйлийн цөлд давж чадаагүй сорилтыг ялан дийлсэн. Тийм ч учраас Тэр мөнхийн аз жаргалд орсон билээ.

Шинэ Гэрээ Мөшэхийн бичсэн Адаам, Хаваах хоёрын түүхийг Есүс Христийн анхны ирэлттэй хэрхэн холбож үздэгийг бад харсан. Одоо хоёр дахь асуудал буюу Шинэ Гэрээнд эдгээр зарчмыг Христийн Хаанчлалын үргэлжлэл буюу бидний одоо амьдарч буй үетэй хэрхэн холбодгийг харъя.

## ҮРГЭЛЖЛЭЛ

Шинэ Гэрээний хэд хэдэн хэсэгт энэ тухай тодорхой гардаг. Харин бид хоёрыг нь л авч үзнэ. Эхлээд Пууль Эхлэл номын 2-3-р бүлгийг хэрхэн онцолсныг хараад, дараа нь Яахооб энэ тухай юу гэснийг харцгаая.

### Пууль

Эхлээд 2 Коринф 11-р бүлгийн 3-р ишлэлд Пуулийн хэлсэн үгийг харъя:

Хаваах могойн заль мэхэнд хууртагдсаны адилаар та нарын бодол санаа ч бас эргэж, Христэд чин сэтгэлээ зориулахад чинь саад болох вий гэж би айж байна (2 Коринф 11:3).

Энэ бүлгийн цааш харвал Пууль Коринф хотынхныг итгэлээсээ буцах вий хэмээн ихэд санаа зовж байсан нь харагдаж байна. Пууль Хаваахын үзүүлсэн сөрөг жишээг иш татсанаараа үнэнч бус байж, Христэд итгэх итгэлээсээ буцахаас сэрэмжлүүлсэн. Мөшхөх Израйльчуудад амласан нутгийг үнэнчээр зорих хэрэгтэй гэдгийг анхааруулахын тулд Хаваах хэрхэн уруу татагдсан тухай бичсэнчлэн, Пууль ч мөн адил жишээг тухайн үеийн итгэгчдэд Христийг дагахын тулд шаардагдах наад захын үнэнч байдлыг заахын тулд ашиглажээ. Хаант улсын үргэлжлэлийн үед олон сүм Сайн Мэдээний жинхэнэ үнэнээс эргэх аюултай нүүр тулж байна. Сүмүүд итгэлээ сахин хамгаалах хэрэгтэй учир нь ингэхгүй бол Адаам, Хаваахын үзсэн аймшигт үр дагаврыг ч үзэж магадгүй.

### Яахооб

Яахооб Христэд итгэгчдийн амьдралд тулгардаг хүнд сорилт, зовлон бэрхшээлийн үүргийг тайлбарлахдаа Пуультай адил үзэл бодлыг илэрхийлсэн. Яахооб 1-ийн 12-15-д ийм үгс байна:

Есүсийн төлөө үнэнчээр зүтгэн зовлон туулсан хүн бүр Ертөнцийн Эзэний өгөхөөр амласан мөнхийн амьдралыг шагнал болгон авна...<sup>14</sup> муу юм хийх хүсэлдээ автагдсан хүн бүр уруу татагддаг.<sup>15</sup> Хүний гэмийг эмэгтэй хүн жирэмсэн болохтой адилтгаж болно. Эхлээд муу хүсэл төрнө. Тэр нь гэмийг төрүүлдэг бөгөөд, гэм нь өсч том болохоороо үхлийг төрүүлдэг (Яахооб 1:12-15).

Яахооб цаад санаагаараа Эхлэл 2-3-тай холбосон нь тодорхой байна. 1-р бүлгийн 14-р ишлэлд тэр хүний “муу юм хийх хүсэл”-ийг гэмд татагддаг хүч хэмээн онцолсон. Сайн мууг таниулагч модноос идэх хүсэл Хаваахад байсан бөгөөд үүнээсээ болж тэр гэм хийсэн билээ.

Хоёрдугаарт, Яахооб үнэнчээр зүтгэн зовлон туулсан хүн “мөнхийн амьдралыг шагнал болгож авна” гэсэн бол эсрэгээрээ гэмийн үр дагавар нь “үхлийг төрүүлдэг”. Амьдрал ба үхлийн хоорондох энэхүү ялгаа нь Адаам, Хаваахын түүхэн дэх амьдрал ба үхлийн ялгаатай ижил байна.

Мөшэх Израйльчуудыг цөлд явахад нь үнэнч итгэлтэй байхыг уриалахдаа Адаам, Хаваахын хэрхэн уруу татагдсаныг бичсэн. Пууль, Яахооб хоёр ч бас Христийн хаант улсын өнөө үед зовлон бэрхшээл тулгарсан ч гэсэн үнэнч итгэлтэй байхад уриалсан. Итгэлээрээ амьдрах үед тохиолдох шалгалт сорилтууд нь бидний жинхэнэ зан чанарыг илчлэн харуулж, мөнхийн амьдралд бидний бэлддэг. Ертөнцийн Эзэний хайр энэрлээр бид Христэд үнэнч үлдэж, аз жаргал бүхий мөнхийн амьдралаар шагнуулахын тулд чадах бүхнээ хийх хэрэгтэй.

Бид сая Шинэ Гэрээнд Адаам, Хаваах хоёрын түүхийг Христийн хаант улсын эхлэл болон үргэлжлэлтэй хэрхэн холбодгийг харлаа. Одоо харин Христийн хаант улсын сүүлийн шат буюу Есүс Христийг хоёр дахь удаагаа ирэх үеийн авралын ажиллагааны төгсгөлтэй холбон авч үзье.

## Төгсгөл

Энэ сэдэв ч мөн Шинэ Гэрээнд олон удаа гардаг, харин бид хоёр хэсгийг нь авч үзнэ. Нэгийг нь Ром номноос, нөгөө нь Үзэгдэл номноос харах болно.

## Ром

Эхлээд Пууль Ром хотын Христэд итгэгчдэд бичсэн захидлаа дуусгахдаа тэдэнд хэрхэн найдвар өгснийг харъя. Ром номын 16-р бүлгийн 20-р ишлэлд ийнхүү бичжээ:

Амар тайвны Их Эзэн адгийн муу ёрын сүнсийг бяц гишгэж ялалтыг та нар өгнө. Их Эзэн Есүсийн хайр энэрэл та нартай хамт байх болтугай (Ром 16:20).

Энд Пууль Ром хотын Христэд итгэгчдэд Есүс Христ хоёр дахь удаагаа ирнэ гэсэн агуу найдварыг дахин сануулжээ. Ингэхдээ тэр Эхлэл номын 3-р бүлэгт гардаг авралын тухай амлалтыг иш татсан байна.

Хичээлийнхээ эхэн хэсэгт үзсэнчлэн Эхлэлийн 3-ын 15-д Ертөнцийн Эзэн могойд хандаж, хожмын нэг өдөр Хаваахын үр удам могойн үр удмын толгойг бяц гишгэнэ гэж хэлсэн. Харин дээрх хэсэгт Пууль Христийг ирэхэд Түүнд итгэгчид адгийн муу ёрын сүнсийг бяц гишгэх болно гэсэн. Түүний дараа бид Христийн хамт ялалт, сүр алдартайгаар хаанчлах болно.

## Үзэгдэл



Эхлэл 2-3-р бүлэгт гардаг түүхийг Христийн хаант улсын төгсгөлтэй холбосон Шинэ Гэрээний өөр нэг хэсэг бол Үзэгдэл ном юм. Энэ номонд Иоган хэд хэдэн удаа амьдрал өгөгч модыг дурджээ. Үзэгдэл номын 2-р бүлгийн 7-р ишлэлд Иоган юу гэж хэлснийг харъя:

Ариун Сүнс сүмүүдэд хандан юу хэлж байгааг чихтэй хүн бүр сонсог. Бүхнийг тэсвэртэйгээр даван туулсан хүнд би Ертөнцийн Эзэний аз жаргалтай цэцэрлэгт буй амьдралын модноос идэх эрхийг өгнө (Үзэгдэл 2:7).

Энд Эхлэл 3-р бүлэгтэй холбосон гэдэг нь тодорхой байна. Адаам, Хаваах хоёрыг амьдрал өгөх модноос идүүлэхгүйн тулд Ертөнцийн Эзэн Эдэн цэцэрлэгээс хөөсөн. Харин Есүсийг дахин ирэх үед Ертөнцийн Эзэн “Өөрийн хүмүүстээ амьдрал өгөгч модноос идэх эрхийг өгнө”. Энэ мод хаана байдаг гэж хэлснийг анзаараарай. Иоган “Ертөнцийн Эзэний аз жаргалтай цэцэрлэгт” гэж тун тодорхой хэлсэн байна. Хинаан оронд урт удаан амьдрал байдаг учраас Мөшөх Израйльчуудыг тийш орохыг уриалсны адилаар Христэд итгэгчдэд бүр илүү агуу аз жаргал бүхий цэцэрлэгт орно гэсэн найдвар бий.

Гуравдугаарт, амьдрал өгөгч модноос идэх хүнтэй холбоотой зүйл бас байна. Иоган хэлэхдээ уг модноос идэх эрхийг “даван туулсан” хүмүүст өгнө гэсэн. Мөшөх Израйльчуудыг Ертөнцийн Эзэнд үнэнч итгэлтэй байхыг уриалахын тулд амьдрал өгөгч модыг дурдсан бол Иоган зөвхөн үнэнч байж, гэмийг тэсч өнгөрүүлсэн хүмүүс л уг модноос иднэ гэжээ.

Эцэст нь Үзэгдэл номын 22-р бүлгийн 1-2-р ишлэлийг харъя. Иоган шинээр бий болох дэлхий ертөнцийг хараад ингэж бичжээ:

Тэгээд ер бусын элч мөнхийн амьдрал өгөх тунгалаг устай голыг харууллаа. Энэ гол хотын голд орших Ертөнцийн Эзэн, хурга Есүс Христ хоёрын ширээнээс гарч хотын гудамж дундуур урсана. Голын эргээр амьдрал өгөгч мод ургана. Сар бүр жимсэлж, жилд 12 удаа үр жимс гаргадаг тэр модны навчис нь үндэстнүүдийг эдгээх хүч чадалтай (Үзэгдэл 22:1-2).

Энэ асуудлаарх Шинэ Гэрээний байр суурь маш тодорхой байна. Есүс Христ авралын ажлаа бүрэн гүйцэтгэхийн тулд дахин ирэх үед Түүнд итгэдэг хүмүүс Эдэн цэцэрлэгт орох ивээлийг хүлээн авна. Харин адгийн муу ёрын сүнс бидний хөл доор бяц гишгэгдэж, бид амьдрал өгөгч модноос идэн, Ертөнцийн Эзэний шинэ бүтээл дотор үүрд мөнх амьдрах болно.

## ДҮГНЭЛТ

---

Бид энэ хичээлээрээ Мөшөх Эдэн цэцэрлэгт байсан Адаам, Хаваах хоёрын тухай бичихдээ Израйльчуудад амласан газар луу явахад нь туслах зорилготой

байсан гэдгийг харсан. Тэр Израйль үндэстнийг Эдэнд болсон үйл явдлыг эргэн санаж, суралцаасай гэж хүссэн. Олон талаараа энэ сургаал бидний өнөөгийн амьдралтай холбоотой. Мөшэх Израйлийг дуудсан дуудлагыг сонссоноор бид ч бас хэрхэн Адаам, Хаваах хоёрын замаар эргэн явж, тэдний алдааг давтахгүй байхыг сурах ёстой юм. Есүс Христэд эцсээ хүртэл найдаж, үнэнч итгэлтэй байснаар бид алдагдсан аз жаргалаа дахин олох болно.

---

**Бага Ричард Л. Прагг (Host)** is Co-Founder and President of Third Millennium Ministries. He served as Professor of Old Testament at Reformed Theological Seminary for more than 20 years and was chair of the Old Testament department. An ordained minister, Dr. Pratt travels extensively to evangelize and teach. He studied at Westminster Theological Seminary, received his M.Div. from Union Theological Seminary, and earned his Th.D. in Old Testament Studies from Harvard University. Dr. Pratt is the general editor of the NIV Spirit of the Reformation Study Bible and a translator for the New Living Translation. He has also authored numerous articles and books, including *Pray with Your Eyes Open*, *Every Thought Captive*, *Designed for Dignity*, *He Gave Us Stories*, *Commentary on 1 & 2 Chronicles* and *Commentary on 1 & 2 Corinthians*.

## ҮГСИЙН ТАЙЛБАР

**бүрэн төгс ялах үе (consummation)** – Христ эргэн ирж, түүхэн дэх Бурханы туйлын зорилгыг биелүүлэх тэрхүү эцсийн үеийн эхлэлийн гурав дахь буюу эцсийн үе шат

**үргэлжлэх үе (continuation)** – Эцсийн үеийн эхлэлийн хоёр дахь буюу дунд шат. Энэ нь Христийн анхны ирэлтээс хойших, эцсийн ялалтаас өмнөх Бурханы хаанчлалын үе

**Ээдэн /Еден/ (Eden)** – "тааламжтай" эсвэл "бахдам сайхан" гэсэн утгатай еврей үг. Бурхан Адам, Ева хоёрыг анх байрлуулсан цэцэрлэгийн нэр

**эдун (edin)** – “тэгш тал нутаг, задгай тал” гэсэн утгатай Вавилон хэлний үг

**Евфрат** – Ээдэн дэх цэцэрлэгээс урсан гардаг дөрвөн их мөрний дөрөв дэх нь. Мөн өнөөгийн Ойрхи дорнод дах хамгийн том мөрний нэр

**нуман хэлбэртэй үржил шимт газар (Fertile Crescent)** – Месопотами орон болон Египетийн хооронд байрлах, өмнө талд нь цөл байрлах, хойд талд нь уулс хүрээлэх хэсэг нутгийг хэлдэг

**Гихун (Gihon)** – Ээдэн цэцэрлэгээс урсан гардаг дөрвөн их мөрөний хоёр дахь нь. Хүш нутгаар урсдаг

**Эхлэлийн үе (inauguration)** – Эцсийн юмсын эхний үе шат. Энэ нь Христийн эхний ирэлт болон Түүний элч нар ба эш үзүүлэгчдийн үйлчлэлийг хэлдэг

**долоон лааны суурь (Menorah)** – Майхан сүмд байрлах долоон лаа бүхий суурь

**Месопотами (Mesopotamia)** – Газар дундын тэнгисийн зүүн зүгт, Тигр Евфрат мөрний хооронд орших нутаг

**Пишон** – Ээдэн цэцэрлэгээс урсан гардаг дөрвөн их мөрний эхний мөрний нэр

**майхан Сүм (tabernacle)** – Гэрээний хайрцаг оршдог, мөн Ертөнцийн Эзэн Израилчуудад онцгой оршихуйгаа харуулдаг байсан нүүдлийн асар

**Тигр (Tigris)** – Ээдэн цэцэрлэгээс урсан гардаг дөрвөн их мөрний гуравдахь мөрөн. Ашурын зүүн захаар урсдаг. Мөн өнөөгийн Ойрхи дорнодын нэгэн их мөрний нэр

**Амьдрал өгөгч мод (Tree of Life)** – Ээдэн цэцэрлэгд байсан онцгой мод. Энэ модноос идсэн хүн мөнх амьдрах хүчтэй